

## Хичээл №13

### СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГ БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛГОХ НЬ (Багийн хэлэлцүүлэг)

#### АГУУЛГА

1. Удирдамж (*Эргэн санах, дасгал ажиллах зааварчилгаа өгөх*)
2. “Нялх хүүхдийн тоглоом наадгайн соёлын утга тайллын судалгаа, орчин үеийн хэрэглээ” сэдэвт судалгааны ажлын танилцуулга
3. Нялх хүүхдийн өлгийн зүүвэр наадгайн хэрэглээ, уламжлуулахуйн өнөөгийн байдал
4. Багийн хэлэлцүүлэг

#### 1. ЭРГЭН САНАХ

Бид түрүүчийн хичээлүүдээр сэтгэлгээ гэж юу болох, түүнчлэн бүтээлч сэтгэлгээ, бүтээлч үйл ажиллагааны тухай ойлголтуудаас эхлээд, онол болон амьдрал дээрх туршлагуудыг судалж, зарим дасгал ажлууд хийсэн. Мөн бүтээлч сэтгэлгээг хэрхэн ашиглах, цаашид хөгжүүлэх арга зүй, аргачлалын талаар ч бас хэлэлцэж дасгал ажиллаж, бусдын туршлагаас чамгүй суралцсан гэж бодож байна. Харин энэ удаагийн хичээлээр монголчуудын уламжлалт, нялх хүүхдийн өлгийн зүүвэр наадгай тоглоомыг судалсан судалгааны ажлын үр дүнг хэрхэн бүтээлч үйл ажиллагаа болгох, түүнчлэн мартагдсан зарим уламжлалыг сэргээж, өнөөгийн залуусын хэрэглээ болгох талаар санал дэвшүүлэх хэлэлцүүлэг хийх гэж байна.

Зааварчилгаа:

- Дэвшүүлсэн асуудлыг шүүн тунгаах,
- Шийдэх асуудлаа тодорхойлох,
- Асуултуудаа гаргах,
- Зөрчилтэй асуудлуудыг буюу шийдэх асуудлаа тодорхойлох,
- Шийдлийн олон хувилбарууд дэвшүүлж ярилцах,
- Оновчтой шийдлийг сонгох,
- ЭТШ- д хүрэх.

## 2. **“НЯЛХ ХҮҮХДИЙН ТОГЛООМ НААДГАЙН СОЁЛЫН УТГА ТАЙЛЛЫН СУДАЛГАА, ОРЧИН ҮЕИЙН ХЭРЭГЛЭЭ” СЭДЭВТ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

2018- 2019 оны хичээлийн жилд СУИС-ийн СС-ийн магистрант Г.Дүүриймаа “Нялх хүүхдийн тоглоом наадгайн соёлын утга тайлалын судалгаа, орчин үеийн хэрэглээ” (Өлгийн зүүвэр наадгайн жишээн дээр) сэдэвт судалгааны ажлаар магистрийн зэрэг хамгаалсан. Мийний бие энэ судалгааны ажлын удирдагч багшаар ажиллаж, судалгааны ажлыг хамтран гүйцэтгэсэн болно.

Бид энэ судалгааны ажлаараа өнөөгийн монгол хүүхэд залуусын дунд буй “бусдын соёлд автах, даган дуурайх үзэгдэл улам бүр ихэссээр, өнөөгийн амьдралын ердийн зүйл болж байгаад шүүмжлэлтэй хандаж, залуучуудын үндэсний соёлын мэдлэгийн санд бага боловч нэмэр өгөх, түүнчлэн монгол соёлын зан үйлийн дотроос хүүхэд залууст үндэстний ухамсарт сэтгэлгээ суулгах, төлөвшүүлэхэд “Хүүхдийн угаалга” хийх зан үйлийн бүрэлдэхүүн хэсгийн нэг, шинээр төрсөн нялх хүүхдэд “Өлгийн зүүвэр наадгай”- н зүйлс бэлэглэх явдал чухал болохыг онцлон үзэж, улмаар түүний утга агуулга, ач холбогдлыг судлан тодруулж, ирээдүй хойч үедээ үндсэн утга агуулгыг нь алдагдуулахгүй өвлүүлэх боломжийн талаар санал санаачлага гаргахыг зорьсон билээ.

Бид тавьсан зорилгын дагуу судлаад *“Монгол нялхсын өлгийн зүүвэр наадгай нь нийт хүн төрөлхтний баларлаг үеийн сэтгэлгээний үлдэц архетип бөгөөд, харин түүнд агуулагддаг аав ээж, авсан ээж, авга нагац нарын хайр халамж, ачлал энэрэл, алив сайн сайхан бүхний ерөөл шингэсэн эсгий үнэг, тээг тэргүүтэй олон тооны эд зүйлс нь монголын эртний нүүдэлчдийн сэтгэлгээний онцлог шингэсэн байгаа тул монголчуудын үндэсний адилсалыг илэрхийлж байна”* гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Энэ дүгнэлт бол “Өлгийн зүүвэр наадгай”-н хэрэглээг амьдралд хэрэгжүүлж хэвших нь монгол хүүхэд залууст үндэсний ухамсар суулгах, төлөвшүүлэх анхдагч хүчин зүйл болохыг харуулж байна. Мөн судалгаандаа үндэслэн орчин үеийн залуусын хэрэглээ болгох хэд хэдэн санал гаргасан нь уг судалгааны ажлын шинэлэг тал, практик ач холбогдол нь гэж үзэж байгаа.

### ***Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага:***

Хүн төрөлхтний даяаршил, шинжлэх ухаан технологийн шинэ эрин үе буюу аж үйлдвэрлэлийн IV хувьсгалын нөлөө, сүүлийн 2 жил гэнэт бий болоод байгаа тахалын нөлөөгөөр улс орнуудын амьдралын нөхцөл байдалд эрс өөрчлөлт гарсан. Энэ бүх байдал хүмүүсийн сэтгэл санаа, амьдралын тухай үзэл бодлыг ихээхэн өөрчиллөө.

Ялангуяа, залуу үеийнхний оюун санаа, амьдралын тухай үзэл бодол урьд өмнөх үеийнхээс нилээд олон талаар өөрчлөгдсөн гэж үзэж болохоор дүр зураг харагддаг.

Дэлхий нийтээр, олон улс даяар гарч буй амьдралын сайн сайхан, хөгжил дэвшлийн төлөөх хүсэл эрмэлзлэл, түүний үр дүнд нь хүн төрөлхтөн бүх нийтээрээ зэрэгцэн хөгжих боломжийг бүрдүүлж байгаа ч залуу үеийнхний дунд үндэсний уламжлалаа үл хайхран бусдын соёлын нөлөөнд хэт автаж даган дуурайх, ахмад үеэ үгүйсгэх, эд хөрөнгө, албан тушаалд шунах гэх мэт хүний ёсонд харш зүйлс байнга давтагдсаар байгаад эцстээ бидний амьдралын энгийн үзэгдэл мэт болох хандлагатай болж ирлээ. Сүүлийн 2 жил олон улс даяар “Шинэ хэвийн байдал”- д алдагдал, хохирол багатай дасан зохицохын тулд судалгаа их хийгдэж байна. Энэ судалгаануудын эхний үр дүнгээс үзвэл, биометрийн зай барих явдал нь бас л 2 талтай байна л даа. Судлаачдын гаргасан дүгнэлтээс хамгийн эвгүй нь юу байна гэхээр, хүмүүс амьд үлдэхийн тулд амин хувиа хичээх сэтгэлгээ ихсэж байна гэсэн дүгнэлт юм. Өнөөгийн энэ байдал улс үндэстэн оршин байх, эсвэл эс орших тухай асуудлыг ч хөндөж байгаа талаар эрдэмтэн судлаач, ахмад үеийнхэн анхааруулсаар л байгаа.

Үүнээс өмнө ч гэсэн Монгол Улсын Төрийн бодлогод ч бас энэ талаар тусч Үндсэн хуулиас эхлээд бүх шатны зохих хууль дүрэм журам, баримт бичгүүдэд үндэсний өв соёлоо хадгалан хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, судлан сурталчилах, хэрэглээ болгох, дархлаажуулах гэх мэт олон заалт, зааврууд тусгагдсан байдаг ч тэр нь бодит амьдрал дээр хэрэгжих нь төдийлөн хангалттай биш учраас өнөөгийн монгол залуусын дунд гадны соёлыг илүүд үзэж, өөрийн үндэсний соёлыг үл хайхран хүнийсэх үзэгдэл илт хавтгайрч, хүүхэд залуучуудын бодол, сэтгэлгээ хүмүүжилд гарч буй өөрчлөлтүүд нь үндэснийхээ уламжлал, ёс суртахуун, зан заншил гэх мэтчилэн үндэсний өвөрмөц онцлогтой соёлоо улам бүр мартсаар байгаа нь бодит үнэн юм.

Жишээлбэл, манай залуус жил бүрийн 10 дугаар сард “сүнсний баяр” буюу “Halloween”-ний өдөр хэмээх гадны соёлын нөлөөг хүртэж, ихээхэн ач холбогдол өгч тэмдэглэдэг болсоор бараг 20-иод жилийн нүүр үзэж байна. Эцэг эхчүүд ч хүүхдүүдээ баярлуулахын тулд энэ баярт багагүй цаг зав, хөрөнгө мөнгө зарцуулж байгаа нь харагддаг.

Мөн манай үндэсний соёлд байх шинээр төрсөн хүүхдийг хамгаалах дом хэмээн уламжлан ирсэн эсгий үнэг, тээг тэргүүтэй нялх хүүхдийн өлгийн зүүвэр наадгайтай утга нэгтэй, америкийн уугуул индианчуудаас гаралтай “Зүүд манагч” буюу “Dream catcher” хэмээх зүйл сүүлийн үед монгол залуусын дунд дэлгэрч, залуус түүнийг ихэд шүтэж, бэлэг дурсгалын зориулалтаар гадаадаас худалдан авах, мөн захиалгаар хийж

худалдаж борлуулах гэх мэт үйл явцууд өрнөж байна. Залуусын сонирхолыг татаад байгаа энэ бүх зүйлс бидний өөрсдийн уламжлалт соёлд эртнээс байсан төдийгүй одоо ч бид хэрэглэсээр байгаа үндэсний уламжлалт соёл билээ. Энэ талаар ард иргэд, ахмад үеийнхэн, судлаачид санаа зовинон ярьж, хэлж, бичиж тэмдэглэж байгаа ч үр дүн муутай байгаа нь төрийн бодлого, судалгаа шинжилгээний ажил, бодит амьдралын хооронд амьд холбоо байхгүйг харуулж буй хэрэг билээ.

Иймээс бид судалгааны асуудлаа 1. Хүүхэд залуучуудыг монгол сэтгэлгээтэй монгол хүн болгон төлөвшүүлэх, 2. Судалгаа шинжилгээний ажлын эцсийн үр дүн амьдралд хэрэгжихүйц байх гэсэн хоёр чиглэлд хандуулж байгаа билээ.

Үүнтэй холбогдуулан хүүхэд, залуучуудын сэтгэлгээний өнөөгийн байдлын эерэг сайн тал ч, сөрөг тал ч хүүхэд эхээс мэндлэхэд хүлээн авч буй орчин, эцэг эх, ах дүүсээс үзүүлж буй хайр халамж, асрал энэрэл өөрчлөгдөж буйтай ихээхэн холбоотой хэмээн үзэж байгаа тул “Хүнээр хүн хийх монгол арга ухаан”- ы ай сав руу, нэн ялангуяа монголыг монголоор нь авч үлдэж, хөгжүүлэх сэтгэлгээтэй монгол хүн болон төлөвшихөд хүүхэд залуусыг хэдийнээс эхлэн бэлдэх нь зүйтэй вэ? гэсэн асуултанд судалгааны үндэслэлтэй хариулт хайсан болно.

Тэгээд бид судалж үзээд юуны өмнө монгол хүн болж төлөвших хамгийн анхны гараа нь шинэ хүүхдийн угаалгын зан үйлээс эхэлнэ хэмээн үзэж байгаа ба энэхүү зан үйлийн бэлгэ тэмдэг болох монгол нялхсын өлгийн зүүвэр наадгайн утга учрыг судлан, олон нийтэд сурталчлан таниулж, дагаж мөрдөж, жинхэнэ монгол хүүхэд залуусыг төрүүлж, өсгөж хүмүүжүүлэхэд бодитой үйл ажиллагаа зохион байгуулах санал санаачлага, уриалга гаргах зайлшгүй шаардлагатай байгааг энэ удаагийн судалгааны ажлаараа дэвшүүлсэн билээ.

### ***Нялх хүүхдийн өлгийн зүүвэр наадгай, түүний ач холбогдол:***

Монгол тоглоом наадгайн ач холбогдлын талаар судалгааны ажил цөөнгүй байдаг. Жишээлбэл, ...Монгол тоглоом наадгай, наадмын зүйлс нь утга агуулга, үүрэг зориулалтын хувьд нүүдэлч малчдын амьдралын онцлогт тохирсон учраас хаана ч тоглоход тохиромжтой, авсаархан, хэний ч сонирхлыг татахуйц, насны хязгаар болзол тавьдаггүй онцлогтойг судлаачид онцлон дурьдаад тэдгээрийн үүрэг зориулалт ач холбогдолоор нь хэд хэдэн төрөл зүйлд хувааж үзсэн байдаг...<sup>1</sup>

---

<sup>1</sup> Нандинбилэг Г. ”Жил” буюу “Хорол” тоглоомын зан үйл, бэлгэдэл // Монгол судлал. МУИС, МХСС-ийн э/ш-ний бичиг: Б.ХХVIII (294).- УБ., 2008.- Х.146-152, Монгол тоглоом ба соёлын өөрчлөлт // Монгол судлал. МУИС, ШУС-ийн э/ш-ний бичиг: Б.ХХХVIII (412).- УБ., 2014.- Х.156-164; Түдэв Л. ... ; Уртнасан Н. Монгол үндэстний биет бус соёлын өв // Монгол тоглоом наадам. -УБ., 2010.-Х70

Тэдгээр судалгааны ажлууд дахь ач холбогдлын талыг нь нэгтгэж дүгнэж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- ...Хүний далд авъяасыг нээн илрүүлнэ;
- Сэтгэн бодох чадвар, амьдралын арга ухааныг хөгжүүлнэ;
- Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх хүмүүжлийн ихээхэн ач холбогдолтой;
- Ганцаараа тоглох тоглоом тэр бүр байдаггүй учраас хамт олонч нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлж, багаар ажиллах чадвар, ёс суртахууны хүмүүжил олгоно;
- Тоглоом наадмын үед хүмүүс инээж наргиж, хөгжилдөн шуугиж байдаг болохоор инээвэл залуужна гэдэгчлэн эрүүл мэнд байж урт удаан наслахад ач холбогдолтой гэж үзжээ. Эдгээрээс зөвхөн 0-3 настай хүүхдийн тоглоом наадгайн ач холбогдлыг авч үзье!

**Өлгийн зүүвэр наадгай гэж юу вэ?** Шинэ төрсөн хүүхдийн угаалгын зан үйлийн үед эцэг эх, ах дүүс, авсан ээж зэрэг ойр дотны хүмүүс нь шинэ хүнд зориулан хийж өлгийн бүснээс нь зүүж бэлэг болгон өгсөн эсгий үнэг, тээг, бяцхан нум сум, загасны нуруу гэх мэт олон зүйлийн утга бэлгэдэлт зүйлсийг нарийн сураар холбож багцалсан, өлгийтэй хүүхдийн толгойн харалдаа, нүдэнд нь харагдахуйцаар монгол гэрийн унинаас дүүжилдэг наадгайн зүйл. Судалгааны зарим бүтээлд нялхсын сахиус наадгай ч гэж тэмдэглэсэн байдаг. Энэ наадгайг монгол хүүхдийн хамгийн анхны амьдралыг таньж мэдэх оньс түлхүүр, ном, багшийг төлөөлөх эд зүйл, өмч гэж үзэж болно. Үүнд л зүүвэр наадгайн гол үүрэг ач холбогдол оршино.

**Нялх хүүхдийн өлгийн зүүвэр наадгайд ямар утга учир агуулагддаг вэ?**

Монгол хүүхдийн хорвоотой танилцах анхны тоглоом нь өлгийн зүүвэр наадгай тул хүүхэд анх наадгайгаа харж элдэв зүйлийн хэлбэр дүрс, өнгө, тэдгээрийн хөдөлгөөн, дуу чимээг чагнан, улмаар гараар оролдон өгч, авах, унагах, түлхэх гэх мэт олон янзын хөдөлгөөн хийх явцдаа наадгайг бүрдүүлэгч монгол сэдэлтэй элдэв дүрс, өнгө, том жижиг, хатуу зөөлнийг хүрч мэдрэн, дүрслэн бодох, төсөөлөх сэтгэлгээ, бие бялдарын өсөлт хөгжилтөд нь монгол бэлгэдэлээр бүрдсэн, монгол ахуй амьдралын сэдэвтэй зүүвэр наадгайн зүйлс ихээхэн нөлөөлж, хүүхдэд монгол ахуйд хүн болж төрсөнийг нь мэдрүүлж, сануулж, таниулдаг нь дамжиггүй. Иймээс, 0-3 насны хүүхдийн хараа, сонсголыг зөв хөгжүүлж, орчноо мэдэрч таних, улмаар ойлгох, бодож сурах суурь үндсийг бүрдүүлэгч бүх шинжүүд монгол нялхсын өлгийн зүүвэр наадгайд бүрэн цогцолсон байна.

Нөгөөтэйгүүр, мэдрэлийн тогтолцоо нялх балчраараа байгаа үе буюу нярай үедээ байгаа хүүхдийн зүүдлэх (үнэгчлэх), айж цочирдон уйлах (хөлсөх) зэрэг нь тэдэнд байгалиас өгөгдсөн зөн совингийн илэрлүүд бөгөөд тэдгээрийг янз бүрийн дом шившлэгээр хариулах хэрэгсэл нь өлгийн зүүвэр наадгай бөгөөд, бэлгэдэлт утгатай янз бүрийн дүрсүүд, түүнд шингэсэн эцэг эх, ахан дүүсийн хайр ивээл, ерөөлийг нялх хүүхэд төрөлхийн зөн совингоороо мэдрэн хүлээн авч өөрийн аврагчийг сэтгэлийн гүнд, далд ухамсартаа хадгалан, цаашдын амьдралдаа ухамсаргүйгээр ашиглан үр удамдаа дамжуулдаг гэсэн таамаглал дэвшүүлж болох юм.



Эртнээс нааш монголчуудын дунд байсаар ирсэн төрөхийн хурим, ураглахын хурим, насласны хурим гэсэн “насны гурван хурим”-ын хамгийн анхны хурим нь бидний судалгааны сэдэвтэй шууд холбоотой юм. Энэ нь нялх балчир хүүхэдтэй холбоотой монгол зан үйлд багтах ба судлаачдын тэмдэглэсэнчлэн “төрөхийн хурим” буюу шинэ төрсөн хүүхдийн угаалга үйлдэх зан үйл юм.

Шинэ төрсөн “хүүхдийн угаалга” хийх зан үйлийг тухайн хүүхэдтэй холбоотой хамгийн анхны зан үйл гэж үзэж болно. Энэ талаар угсаатны зүйн чиглэлийн хүрээнд нилээд судлагдсан. Харин сүүлийн үед соёл судлал, соёлын хүн судлал, түүн дотор хүүхэд насны соёлыг судлах зэрэг судалгаа шинжилгээний салбар, чиглэлээр нарийвчлан судалж эхлээд байна.

Үүнтэй холбогдуулаад “Хүүхэд насны соёл”-ын тухай сонирхуулахад, ...Хүүхэд насны соёл нь олон соёлт орчин дахь хүний адилсалын нэгэн салбар бөгөөд даяаршлын нөхцөлд угсаатны ухамсрыг тээгч, нэгэн угсаатны төлөөлөл болохын хувьд өөрийн

угсаатны адилсалтай, итгэлтэй байх боломжийг олгодог...<sup>2</sup> тул монголчуудын хүүхдийн угаалгын зан үйлийг монгол соёлын орчин дахь монгол хүний адилсалын анхдагч суурь нь юм гэж үзэж болохоор байна.

Өлгийн зүүвэр наадгай хэмээн нэрлэсний гол учир нь хүүхдийн угаалгын ёслолд ирсэн хүмүүс тус тусын сайн сайхны ерөөлийг шингээсэн бэлгэдэлт угатай зүйлсийг хүүхдийн өлгийн бүснээс зүүж өгдөг, найр өндөрлөсний дараа аав ээж нь тэдгээр зүйлсийг нэг багц болгон, нарийн суранд зангидаж хүүхдийн нүдэнд харагдаж байхаар гэрийн унинаас дүүжилж өгдөгтэй холбоотой.

Зүүвэр наадгайг бүрдүүлэгч эсгий үнэг, загасны нуруу тээг, нум сум, зоос, хонх тэргүүтнийг хүүхдэд хор хөнөөл хүргэж болзошгүй далдын онгоныг хуурахад чиглэсэн, эцэг эх, ахан дүүсийн хайр халамжийн илэрхийлэл хэмээн үздэг ажээ.

Энэ тоглоом наадгайнаас гадна хүүхдийн угаалгын зан үйлийн дотор хүүхдэд “нэр өгөх” чухал нэгэн үйл бас байдаг. “Нэр өгөх” гэдгийн хүндэтгэл нэр нь “Нэр хайрлах” гэсэн хэллэг байж таарна. Эндээс тухайн хүүхдэд нэр хайрлан, хайр халамжаа илэрхийлсэн бэлгэдэлт зүйлсийг өлгийн бүснээс нь зүүж өгөх зэрэг үйлүүд нь **хайр** хэмээх нэгэн үндэстэй, хүнд дутагдаж болшгүй хайрын сэтгэлээс угшилтай хэмээн үзэж хайрын онолын үүднээс тайлбарлахыг бас энэ судалгааны ажилдаа оролдсон байгаа.

Орчин үеийн сэтгэл судлалын онолын үүднээс тайлбарлавал, Хүн төрнө гэдэг нь инстинкттэй адил өгөгдсөн байсан нөхцөл байдлаасаа гэнэт тасарч цоо шинэ, тодорхойгүй, яаж ч өөрчлөгдөж мэдэхээр нөхцөл байдал руу шидэгдэх мэт болдог гэнэ.

Ингэж эхийн хэвлийд байсан үеийн нэгэнлэг байдал буюу эх үрийн симбиотик нэгдэл төрсний дараа өөрчлөгдөхөд хүүхэд ганцаардмал байдалд ордог байна. ...Эх үрийн симбиотик нэгдэл\* төрсний дараа өөрчлөгдөхөд хүүхдэд хэрэгтэй хамгийн чухал зүйлсийг (эхийн сүү, биеийн дулаан ...гэх мэт) эх нь өөрийхөө дотор амьд буй зүйлсээсээ үргэлжлүүлэн өгч хүүхдийнхээ амьдрах боломжийг ханган тэлж, цаашлаад өөрөө өөрийнхөө амьд байх сэтгэлээ хүртэл хүч оруулж чаддаг... гэсэнтэй холбон үзэж болмоор санагдана.

Эх үрийн симбиотик нэгдэл төрсний дараа өөрчлөгдөхөд хүүхдэд төрдөг тусгаарлагдсан байдал нь айдас төрүүлдэг ба бүх төрлийн айдсын эх үүсвэр болдог гэнэ. Хүн төрөх үеийн сэтгэл зүйн энэ нарийн үйл явцыг хүн төрөлхтөн эртнээс мэддэг байсан ба эрт үедээ төрөл бүрийн дом шившлэгээр хариулан эерүүлдэг байсны нэг гэрч

---

<sup>2</sup> Ганжаргал М. Хүүхдийн угаалгын ёс соёлд орохуйн (инкультурацийн) зан үйл болох нь // Монголын соёл, урлаг судлал.- Боть XXVI: Тусгай дугаар, “Эрдмийн чуулган-2018” эрдэм шинжилгээ, онол практикийн хурал.- УБ.: Линограф ХХК., 2018.- Х.51-60.

\*

нь монголчуудын нялх хүүхдийг үнэгчлэхэд домнодог эсгий үнэг зэрэг төрөл бүрийн амьтны дүрс бэлдэж дэргэд нь байлгадаг зан үйлийн зүйл байж болох юм.

Зүүвэр наадгайн бүрдвэрүүд дотороос ...хамгийн анх эсгий үнэгийг хүүгийн эцэг, эсвэл нагац нь өөрийн гараар хайчлан зүүж өгдөг домтой. Бусад нь хүүхдийн угаалга мялаалгын зан үйлтэй холбоотой бөгөөд хүүхдийн угаалганд уригдсан хүүмүүс хийж авч ирдэг заншилтай. Хүүхдийн угаалга гэдэг бол Милаан тэнгэрт таниулах ёслол бөгөөд энгийнээр хэлэхэд нялхсыг төрөөд гурав хоноход борви тойгны шөлөөр угаан, хүүхдэд нэр өгөх ёс юм...<sup>3</sup> ажээ. Судлаачид энэхүү ёсыг “Хүүхдийн угаалгын ёслол бол монголчуудын оюуны соёлын томоохон зан үйл”... ба “насны гурван хурим”-ын анхных тул ...заавал ёсолдог амь амьдралын баталгаа шинжтэй... гэсэнтэй<sup>4</sup> бид бас санал нэг байгаа тул үүнийг нягтлан судалж залуучуудад уламжлуулан өвлүүлэх зүйлсийн жагсаалтын хамгийн эхэнд орно гэж үзэж байгаа билээ.

### **3. НЯЛХ ХҮҮХДИЙН ӨЛГИЙН ЗҮҮВЭР НААДГАЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, УЛАМЖЛУУЛАХУЙ**

Бидний анхаарах дараагийн нэг чухал зүйл бол “нялх хүүхдийн өлгийн зүүвэр наадгайн хэрэглээний өнөөгийн байдлыг судлаад, судалгааны үр дүнд үндэслэн хойч үедээ уламжлуулах арга замуудыг эрж хайх явдал гэж үзэж байна.

Яагаад бид үүнийг заавал уламжлуулах шаардлагтай вэ гэхээр, ...Нялхсын сэтгэхүй нь дүрс хэлбэр, өнгө зүс, дуу авиа, хүрэлцээ (мэдрэмж) зэрэг тодорхой зүйлээр эхлэн хөгждөг...<sup>5</sup> учраас өлгийн зүүвэр наадгайн ач хобогдол хүүхдийн цаашдын өсөлт хөгжилтөд үлэмж өндөр. Иймээс, бидний анхаарлыг татаж буй зүүвэр наадгайн хэрэглээ монгол хүн гэх өвөрмөц онцлогийг шингээсэн жинхэнэ монгол хүн болж төлөвшихөд хамгийн эхлэлийн гараа болох боломжтой санагдана.

Өлгийн зүүвэр наадгайн хэрэглээний ач холбогдолыг тайлбарлан ойлгуулах, түүний бүтэц бүрэлдэхүүн тус бүрийн утга агуулгыг олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх ажлуудыг зохион байгуулах, зүүвэр наадгайнаас сэдэвлэсэн төрөл бүрийн үйл ажиллагаа, сургалт, багт наадам гэх мэт ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлэх,

---

<sup>3</sup> Нандинбилиг Г. Монгол тоглоомын соёл хийгээд тэнгэр, лус савдгийн шүтлэг // Монгол судлал эрдэм шинжилгээний бичиг, XXXII.- УБ., 2010.- Х.139-143.

<sup>4</sup> Ганжаргал М. Хүүхдийн угаалгын ёс соёлд орохуйн (инкультурацийн) зан үйл болох нь // Монголын соёл, урлаг судлал.- Боть XXVI: Тусгай дугаар, “Эрдмийн чуулган-2018” эрдэм шинжилгээ, онол практикийн хурал.- УБ.: Линограф ХХК., 2018.- Х.- Х.55; Дулам С., Нандинбилиг Г. Насны онцлогтой холбоотой монгол заншлууд // Аман зохиол судлал: Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний цуврал XXXVI.- УБ., 2015.- Х.83.

<sup>5</sup> Түдэв Л. Хүүхдээ цагт нь тодруулахуй / Лодонгийн Түдэв албан ёсны Facebook.- 2014.03.26.

соёлын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний загварууд хийж сурталчлах нь ирээдүйн жинхэнэ монгол хүүхэд, залуус төрөн гарахад үр нөлөөтэй ажил болно хэмээн төсөөлөгдөж байна.

Өнөө үед нялхсын өлгийн зүүвэр наадгайн уламжлалт хэрэглээ хумигдаж байгаа ч эмэгтэй зураач, уран бүтээлчид энэ сэдвээр уран бүтээл туурвиж, зарим нь бэлэг дурсгалын бүтээгдэхүүний багц урлан бүтээж байгаа сайн тал ажиглагдаж байна.



*Зураг 2. Б.Мөнхцэцэг. Хүй дарсан чулуу,  
2016-2017*



*Зураг 3. Ж.Аунанаран.  
2011*



а



б



*Зураг 12. О.Үржсинханд. Үр минь*



*Зураг 13. Ч.Мөнхцэцэг. Эхийн сэтгэл бүтээлийн эскиз*



*Зураг 14. Ц.Солонго. Өлгийн зүүвэр наадгай*

**Судалгааны даирамд бидний олж мэдсэн нэг зүйл бол:** уугуул америкчуудаас гаралтай уугуул америкчуудын нэгдмэл байдлын илэрхийлэл болж аялал жуулчлалд ч өргөнөөр хэрэглэгдэж буй *Dream catcher* буюу зүүд манагч, түүний хэрэглээ бидний анхаарлыг ихээр татсан юм.

Зүүд манагч нь олон улсуудад хэрэглэгдэж байсан төдийгүй Энэтхэгт эв найрамдлын бэлгэ тэмдэг байсан бол Америкийн анхны соёлыг тодорхойлох зүйл хэмээн үздэг байна. Мөн залуу хосууд гэрлэхэд аз жаргал ерөөж зүүд манагч хийж бэлэглэдэг уламжлал ч байжээ. Эрт үед бол зүүд манагчийг уд модны мөчрөөр урладаг байсан бөгөөд ялангуяа Америкийн газар нутагт ихээр ургадаг улаан уд модыг их ашигладаг байсан гэнэ. Түүнийг хийхдээ уд модоор цагираг хийж, ургамлын иш, амьтны булчин шөрмөсөөр тор урлан, шар шувууны өд өлгөдөг байжээ. Харин орчин үед үүнийг байж болох бүхий л материалаар урлаж, зөвхөн орны толгойд гэлтгүй зочдын өрөөнд, толины тусгал хүрэх газарт, машиндаа, гоёл чимэглэлд хэмээн хаа сайгүй хэрэглэх болсон. Мөн энэ нь уугуул америкчуудын нэгдмэл байдлын илэрхийлэл болж аялал жуулчлалд ч өргөнөөр хэрэглэгдэж байгаа нэг жишээ байна.

Өнөө үед *Dream catchers*- ийг буюу зүүд манагчийг гар урлалын янз бүрийн аргаар төрөл бүрийн хэмжээгээр хийж болох бөгөөд ихэвчлэн бөмбөлөг, өд, даавуу, арьсаар чимэглэсэн байдаг. Орчин үеийн гар урлалын бүтээгдэхүүн болох *Dream catchers* нь америкчуудын итгэл үнэмшилд үндэслэсэн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болжээ. Манай улсын хувьд ч зүүд манагчийг өсвөр насны охид шүтдэг болсон учраас захиалгаар хийж худалдаалдаг залуус байдаг ажээ.

Уугуул америкчууд буюу индианчуудын, тэр дундаа Ожибвэ омгийнхонд монголчуудын зүүвэр наадгайтай адил утга агуулгатай, бас адил зориулалттай гэж үзэж

болох “Dream cacher” буюу зүүд манагч нь тэдний хамгийн гайхалтай өв уламжлалын нэг гэнэ. 1960-1970-аад оны үед америкчуудын дунд тархсан энэхүү бяцхан эд олон тооны домог яриа дагуулдаг. Зарим нь энэ бол зүгээр л уугуул америкчуудын эв нэгдлийн бэлгэдэл гэж үздэг байхад нөгөө хэсэг нь хүний зүүдний ертөнц дэх хамгаалагч гэж үздэг ажээ. Энэ утгаараа манай нялх хүүхдийн “үнэгчлэх” гэдэгтэй адил юм.

Зүүд манагчтай холбоотой нэгэн сонирхолтой домог яриа өгүүлэхэд “Эртний индиан омогт бяцхан хүүхдүүдийг хамгаалж, тэдэнд анхаарал халамж тавьдаг Асибикааши хэмээх аалзан эмэгтэй амьдардаг байжээ. Гэвч индианчууд нутаг сэлгэж, Хойд Америкийн тал нутгаар амьдрах болсноор аалзан эмэгтэй хүүхэд бүрт хүрч чадахаа больжээ. Тиймээс эмээ нар, ээжүүд ийм нэгэн аалзны торыг илэрхийлсэн зүүд манагч хийж, үүгээрээ аалзан эмэгтэйг орлуулан гэртээ байлгадаг болсон” гэсэн домог яриа байдаг байна. Мөн түүнчлэн, ...төрөл бүрийн мөчир, булчин шөрмөс, өд сөд гэх мэт зүйлээр хийдэг байсан эртний зүүд манагч нь ихэвчлэн шинэ төрсөн хүүхдэд өвөө эмээгээс нь уламжлагдан ирдэг байсан бөгөөд нэг талаар анхны эд хогшил нь болдог байжээ. Тиймээс өвөө эмээ нар бяцхан хүүхэд унтаж байхад зүүд манагч хөдлөх нь сайн сайхныг зүүдэлж байна хэмээн баярладаг... гэнэ. Бас,...Шөнийн агаарт сайн муу зүүд бүхэн холилдон байдаг бөгөөд сайн зүүднүүд нь аалзны тор мэт зүүд манагч дундуур хэрхэн гарахаа мэддэг гэж индиачууд үздэг. Өд бүхний хөнгөн хөвсгөр хөдөлгөөн улам илүү сайхан зүүд дуудах чадалтай байхад, муу зүүд улам бүр төөрөлдөж, өглөөний нарны туяанд яг л бяцхан шүүдэр шиг хайлан алга болдог хэмээн домогт өгүүлдэг юм байна.

Энэ домогт гарч буй утга агуулгыг “Зүүвэр наадгайнхтай харьцуулж үзвэл,...эртний зүүд манагчид ихэвчлэн шинэ төрсөн хүүхдэд өвөө эмээгээс нь уламжлагдан ирдэг байсан бөгөөд нэг талаар анхны эд хогшил нь болдог... гэдэг нь манай монголчуудын хүүхдийн угаалга хийх зан үйлийн нэг хэсэг болох авга болон нагац ахан дүүс нь зүүвэр наадгай бэлтгэн бэлэглэхтэй адил утгатай байна. Харин зүүсэн эд зүйлсээрээ бага зэрэг ялгагдаж байгаа төдийгүй монгол нялхсын зүүвэр наадгай маш олон тооны эд зүйлсээс тогтож байгаа нь бидэнд “Зүүд манагчаас” илүү олон янзын шинэ зүйлс хөгжүүлж хийх боломжийг олгож байна.

...Өвөө эмээ нар бяцхан хүүхэд унтаж байхад зүүд манагч хөдлөх нь сайн сайхныг зүүдэлж байна хэмээн баярладаг... гэдэг нь бидний “хүүхэд үнэгчлэх” гэсэн ойлголттой адилхан утгатай байгаа нь нярай хүүхдийн үнэгчлэхэд хийх дом нь балар эртний үеэс улбаатай буюу баларлаг үеийн эртний соёлын архетип бөгөөд хэлбэр дүрс, хэрэглэсэн эд, тэдгээрийн тоогоороо л ялгаатай гэж үзэхээр байна. Тиймээс өлгийн зүүвэр наадгайг

бүрдүүлж буй эд зүйлс нь өөр өөрийн үндэстэн угсаатны онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлт утгатай зүйлс байдаг нь судалгаанаас харагдаж байна.

Харин тэдгээр (өлгийн зүүвэр наадгай, зүүд манагч)- ийг өдий хүртэл уугуул утгаар нь өвлөн авч яваа үндэстэн угсаатнууд харин цөөн байдаг бололтой ч одоогийн америкчууд овжноор ашиглан эв нэгдлийн бэлгэ тэмдэг болгон дэлхий нийтээр тараан олон улс орны залуучууд түүнийг сонирхон хэрэглэдэг, бас нэг нэгэндээ сайныг ерөөсөн бэлэг дурсгал болгон хэрэглэдэг заншил тогтоод байгаа ажээ.

*Өлгийн зүүвэр наадгай, Зүүд манагч хоёрын харьцуулалт*

№	Зүүлэлт	Өлгийн зүүвэр наадгай	Зүүд манагч
1		онголчуудын насны гурван хуримын мгийн анхны хурим нь хүүхэд угаах үйл. Нялхсыг төрөөд гурав хоноход орви тойгны шөлөөр угаан, хүүхдэд нэр өх ёс юм.	=
2	Эвлүүлэгч	үүхдийн эцэг, эсвэл нагац нь эсгий үнэг йчилж өгнө. Бусад зүйлсийг ах дүү, маатан садангаас хийж, бэлдэж өгнө	өө эмээ нар нь
3	Ориулалт	үүхэд саатуулах, хамгаалах	үүхэд саатуулах, хамгаалах
4	Утга агуулга	үүхдийг нялх нярай байх үед нь мгаалах, сайн сайхныг ерөөх утга уулгатай байснаа, улмаар хөлд орох эс үүрэг зориулалт нь нэмэгдэж вцсанд нь чимэг зүүсгэл болж рэглэгддэг. сгий үнэг, загасны нуруу тээг, нум сум, ос, хонх тэргүүтнийг хүүхдэд хор нөөл хүргэж болзошгүй далдын гоныг хуурахад чиглэсэн, эцэг эх, ахан үсийн хайр халамжийн илэрхийлэл мээн үздэг ажээ.	Цөнийн агаарт сайн муу зүүд бүхэн лилдон байдаг бөгөөд сайн үднүүд нь аалзны тор мэт зүүд нагч дундуур хэрхэн гарахаа мэддэг ж индиачууд үздэг. Өд бүхний нгөн хөвсгөр хөдөлгөөн улам илүү йхан зүүд дуудах чадалтай байхад, у зүүд улам бүр төөрөлдөж, төөний нарны туяанд яг л бяцхан гүдэр шиг хайлан алга болдог мээн үзнэ. өн уугуул америкчуудын эв гдлийн бэлгэдэл гэж үздэг байхад гөө хэсэг нь хүний зүүдний ертөнц ж хамгаалагч гэж үздэг.

5	Бүтэц	гий үнэг, тээг, явуу, нум сум, 9 нүхт глоом, хонх, төрөл бүрийн амьтны рс, зоос чимэг ...гэх мэт олон зүйлстэй.	дон цагираг, шөрмөс утас, өдөн жлага
6	Эд	гий, өнгийн даавуу, торго, арьс, сур, д, төмөр, яс, явуу,	рөл бүрийн мөчир, булчин шөрмөс, сөд. т үед бол зүүд манагчийг уд модны чрөөр урлаад, амьтны шөрмөсөөр р татаад, шар шувууны өд өлгөдөг йсан.
7	Бэрлээ	үүхдийн нүдэнд эвтэй байрлалд, инаас уяж унжуулна.	үүхдийн нүдэнд эвтэй байрлалд үнэ
8	Ач холбогдол	ялхсын сэтгэхүй нь дүрс хэлбэр, өнгө с, дуу авиа, хүрэлцээ (мэдрэмж) зэрэг дорхой зүйлээр эхлэн хөгждөг.	мерикийн анхны соёлыг дорхойлох зүйл хэмээн үздэг. ндианчуудын эв нэгдлийн бэлгэдэл лдог.

### ДҮГНЭЛТ ба САНАЛ

Судлаачдын “Хүүхдийн угаалгын ёслол бол монголчуудын оюуны соёлын томоохон зан үйл”... ба “насны гурван хурим”-ын анхных тул ...заавал ёсолдог амь амьдралын баталгаа шинжтэй... гэсэнтэй бид санал нэг байгаа ба судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлт, саналыг гаргаж байна.

1. Монгол нялхсын өлгийн зүүвэр наадгай нь нийт хүн төрөлхтний баларлаг үеийн сэтгэлгээний үлдэц архетип болох нь монголчууд болон америкийн уугуул Ожибвэ омгийн “зүүд манагч” зэргээс ойлгогдож байна. Харин түүнд агуулагддаг аав ээж, авсан ээж, авга нагац нарын хайр халамж, ачлал энэрэл, алив сайн сайхан бүхний ерөөл шингэсэн эсгий үнэг, тээг тэргүүтэй олон тооны эд зүйлс нь монголын онцлог шингэсэн үндэсний адилсалыг илэрхийлж байна.

2. Иймээс нялх балчир хүүхдийн байгалиараа байгаа зөн совингоор дамжин тухайн хүүхдийн сэтгэлийн гүнд шингэж насан туршид нь түүнд гэр бүл, ураг төрлийн элгэмсэг дотно харилцааг сануулж, ухааруулж байдгийн зэрэгцээ монгол хүүхэд тэдгээрийн тусламжтайгаар монгол арга ухаанаар ертөнцийн юмс үзэгдлийг танин мэдэж, ойлгон жинхэнэ монгол хүн болон төлөвшдөг тул шинэ хүүхдийн угаалгыг хуучин уламжлалаар нь сэргээн хийх талаар нийгэмд чиглэсэн бүтээлч үйл ажиллагаа шаардлагатай байна.

3. Зүүвэр наадгайг бүрдүүлэгч эсгий үнэг, тээг тэргүүтэй олон янзын эд зүйлс нь хүүхдийг нялх нярай байх үед нь хамгаалах, сайн сайхныг ерөөх утга агуулгатай байснаа, улмаар хөлд орох үеэс үүрэг зориулалт нь нэмэгдэж хувцсанд нь чимэг зүүсгэл

болж хэрэглэгддэг байна. Энэ нь бидэнд түүнийг олон төрөл зүйлтэй болгон хөгжүүлж, орчин үеийн хэрэглээ болгох боломжийг бүрдүүлж байна.

4. Олон нийтийн дунд явуулсан судалгааны үр дүн, уран бүтээлчдийн бүтээлч үйл ажиллагаа, залуучууд америкийн эв нэгдлийн бэлгэдэл болсон индианчуудын “зүүд манагч”-ийг дууриан хэрэглэх болсон зэрэг нь зүүвэр наадгайг орчин үед бэлэг дурсгалын зориулалтаар олон янзын чимэглэлийн зүйлс хийж, хөгжүүлж болохыг харуулж байна.

#### **Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлье!**

1. Зүүвэр наадгайг уламжлалын дагуу хийж хэрэглэн хэвшүүлэх ажлыг санаачлан СУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хамтран дараах чиглэлээр хэрэгжүүлж болно. Үүнд:

СС-ийн Соёл судлалын профессорын баг, ДДУС-ийн Дизайн урлагийн профессорын баг хамтран дараах ажлуудыг санаачлах

- СС-с Уламжлалт утга агуулгыг сурталчилсан богино хэмжээний тогтмол сургалт зохион байгуулах (Үүнийг хуримын ордонтой хамтарч хэрэгжүүлж болно)
- ДДУС-с гар урлалын бүтээгдэхүүнүүд хийх,
- ХУС, ТУС, БУС-с зохиол бүтээл туурвин найруулан тоглох,
- РТМУС олон нийтэд сурталчилах зэрэг ажлуудыг зохион байгуулж болно.

Нийгэмд чиглэсэн үндэсний өв уламжлалыг дэмжин дэлгэрүүлэх дээрх маягийн үйл ажиллагааг жил бүрийн 6 сарын 1-нд тохиодог эх үрсийн баяр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, 8-р сарын 8-нд болдог аавуудын өдөр зэрэг тэмдэглэлт өдрүүдэд тогтмол шинэ агуулгаар баяжуулан, сонирхолтой хэлбэрээр зохион байгуулдаг “брэнд” бүтээгдэхүүн болгох хэрэгтэй гэж үзэж байна.

#### **4. БАГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

##### ***Багийн зохион байгуулалт:***

<b>№</b>	<b>Багийн нэр</b>	<b>Үүрэг</b>	<b>Гаргасан санал</b>
	р баг	лбэр дүрс, тоглоомын төрлийг нарийвчлан тодруулах	
	р баг	га бэлгэдэлийг нарийвчлан тодруулах	
	р баг	гвар шинэчлэх санал боловсруулах	
	р баг	инэ, сонирхолтой загвар боловсруулах	
	р баг	л ажиллагааны санал боловсруулах	
	р баг	слийн санал боловсруулах	

***Анхаарах зүйлс:***

- Дэвшүүлсэн асуудлыг шүүн тунгаах,
- Шийдэх асуудлаа тодорхойлох,
- Асуултуудаа гаргах,
- Зөрчилтэй асуудлуудыг буюу шийдэх асуудлаа тодорхойлох,
- Шийдлийн олон хувилбарууд дэвшүүлж ярилцах,
- Оновчтой шийдлийг сонгох,
- ЭТШ- д хүрэх.

***Багуудад тавигдах шаардлага:***

1. Баг бүр хариуцсан ажлаа гүйцэтгэхдээ хичээлээр үзсэн онол, хийсэн дасгал ажлуудаас ашиглах,
2. Хийж буй ажилдаа тохирсон шинэ дасгалын загвар боловсруулах.

**Сэдэвт ашигласан материал:**

1. Дүүриймаа Г. Нялх хүүхдийн тоглоом наадгайн соёлын утга тайллын судалгаа, орчин үеийн хэрэглээ (Өлгийн зүүвэр наадгайн жишээн дээр): Магистрын зэрэг горилсон бүтээл / э/ш удирд. Б.Мөнхцэцэг.- Хамгаалсан, 2019.01.14.- УБ., 2019.- 69х.
2. Ганжаргал М. Хүүхдийн угаалгын ёс соёлд орохуйн (инкультурацийн) зан үйл болох нь // Монголын соёл, урлаг судлал.- Боть XXVI: Тусгай дугаар, “Эрдмийн чуулган-2018” эрдэм шинжилгээ, онол практикийн хурал.- УБ.: Линограф ХХК., 2018.- Х.51-60.
3. Дулам С., Нандинбилиг Г. Насны онцлогтой холбоотой монгол заншлууд // Аман зохиол судлал: Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний цуврал XXXVI.- УБ., 2015.- Х.85-86.
4. Нандинбилэг Г. Монгол тоглоом ба соёлын өөрчлөлт // Монгол судлал. МУИС, ШУС-ийн э/ш-ний бичиг: Б.XXXVIII (412).- УБ., 2014.- Х.156
5. Психологи / Орч. С.Молор-Эрдэнэ, Б.Жавзан, П.Мягмаржаргал, Г.Ундармаа.- УБ.: МОНСУДАР, 2014.- Х.274-275.
6. Сампилдэндэв Х. Аман зохиол судлал / Эмхт. Б.Дайриймаа, Ч.Заяасүрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2015.- Х.158.
7. Түдэв Л. Хүүхдээ цагт нь тодруулахуй / Лодонгийн Түдэв албан ёсны Facebook.- 2014.03.26.
8. Уртнасан Н. Монгол үндэстний биет бус соёлын өв.//Монгол тоглоом наадам. -УБ., 2010.-Х71-82
9. Фромм Э. Хайрлах урлаг / Орч. А.Баярцэцэг, Г.Баянжаргал, С.Батзориг ба бус.- УБ.: Монсудар, 2015.- Х.34

***Уран бүтээлчидтэй хийсэн ярилцлагууд:***

1. Зураач Б.Мөнхцэцэгтэй хийсэн ярилцлага.- УБ.,2019 2018.12.26.- СУИС, ДДУС, 115 тоот.

2. Зураач Ж.Анунаран нартай хийсэн ярилцлага.- 2019.01.07-ны өдөр Ж.Анунарангийн урланд.

### **ДААЛГАВАР**

**Дээрх судалгааны үр дүнд үндэслэсэн бүтээлч үйл ажиллагааны саналыг шүүн тунгаагаад, өөрсдийн саналыг дэвшүүлж, семинарын хичээлээр хэлэлцүүлээрэй!**

### **Анхаарах зүйлс!**

**Дэвшүүлэх саналаа багаараа хэлэлцэж сонголт хийсэн байх шаардлагатай.**

**Үүний тулд өнгөрсөн хичээлүүдэд үзсэн энгийн тоглоомын аргуудаас сонгож хэрэглэсэн байх.**